

**Оюуныг нээгч “Оюун түлхүүр” сургаал хийгээд  
сэтгэл хөдлөлийн оюун ухаан (EI)-ы өгүүлэмж**

**Отгонбаярын АНХИЛУУН\***

Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,  
Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, Монгол хэлний тэнхим

**Дашдамбын ЭРДЭНЭСАН**

Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,  
Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, Монгол хэлний тэнхим

**Received:** 31 May 2025 / **Accepted:** 15 October 2025 / **Published:** 30 December 2025

**Хураангуй:** Тус өгүүлэлд сэтгэл судлал, тархи судлал, социологи, боловсролын буюу салбар дундын шинжтэй, Өрнө дахинаа XIX зуунаас судлагдаж эхэлсэн “Сэтгэл хөдлөлийн оюун ухаан” (Emotional Intelligence) нь Монголын бичгийн дурсгал болох оюуныг нээгч “Оюун түлхүүр” сургаалын зохиолд өгүүлэгдсэн байх магадлалыг таамаглаж, тус зохиолын гурван гар бичмэлийг академич Ц.Дамдинсүрэнгийн “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршой” бүтээлд хэвлүүлсэн хувилбартай харьцуулан ажиглаж, цаашидад сэтгэл хөдлөлийн оюун ухааны таних, хэрэглэх, ойлгох, удирдах гэсэн дөрвөн түвшний 26 чадвартай харгалзуулан шинжлэв. Эндээс монголын уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааныг орчин үеийн шинжлэх ухааны үүднээс авч үзэн, өнөөгийн боловсролын үзэл баримтлал, түүн дотор “Иргэний ёс зүйн боловсрол” ба “Хүн нийгэм” гэсэн 2 хичээлийн хөтөлбөрт тусган интеграцчилж ашиглах боломжтой гэсэн санал дэвшүүлэв.

**Түлхүүр үгс:** Сургаалын зохиол, эх судлал, “Оюун түлхүүр” сургаал, сэтгэл хөдлөлийн оюун ухаан

**The “Oyun tülkigür” or “Key to Wisdom” and  
Statement of Emotional Intelligence**

**ANKHILUUN Otgonbayar**

Department of Mongolian Language, School of Social Sciences and Humanities,  
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

**ERDENESAN Dashdamba**

Department of Mongolian Language, School of Social Sciences, and Humanities,  
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

\* © Author(s), 2025 Email: [ankhiluun@msue.edu.mn](mailto:ankhiluun@msue.edu.mn).



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

**Abstract:** This article explores the interdisciplinary concept of Emotional Intelligence, which has been studied in the West since the 19th century across the fields of psychology, neuroscience, sociology, and education. We hypothesize that elements of emotional intelligence may be implicitly present in the Mongolian written heritage-specifically, in the wisdom literature *The Key to Wisdom* (*Oyun tülkigür*), a traditional moral teaching. To examine this, we compared three manuscript versions of the text with the published version included in Academician Ts. Damdinsuren's compilation "*mongyul-un uran jokiyaal-un degeji jayun bilig orusibai*" (*A Hundred Treasured Works of Mongolian Literature*). We further analyzed the content in relation to the four core domains of emotional intelligence: perceiving, using, understanding, and managing emotions-each of which includes a set of 26 distinct skills. Based on our findings, we propose that Mongolian traditional pedagogical philosophy can be revisited through the lens of contemporary scientific understanding and suggest its potential integration into modern educational frameworks, particularly within the curricula of "Civic Ethics Education" and "Human and Society" subjects.

**Keywords:** Wisdom Literature, Text-Linguistics, "Key to Wisdom", Emotional Intelligence

---

## 1. Удиртгал

Аливаа улс орон, түүн дотор Дорно дахины орнууд нь сургаалын зохиолын баялаг өв уламжлалтай бөгөөд тэдгээрийн нийгэмд үзүүлэх нөлөө, ач холбогдлын талаар гадна, дотнын судлаачид цөөнгүй тодорхойлон өгүүлсэн нь бий. Тухайлбал, академич Ц.Дамдинсүрэн "Зүйр цэцэн үгээс эхлээд ерөөл, магтаал, үлгэр домог, баатарлаг тууль хүртэл ардын аман зохиолын олон зүйл бол цөм залуучуудад шударга ёс, баатар зориг, эх оронч үзэл, зан суртахуун зэрэгт хүмүүжүүлэх чухал хэрэглэгдэхүүн болох" (Дамдинсүрэн, 1957:18) гэсэн байдаг бол The Lexham Bible Dictionary (2016) тольд "Сургаалын зохиолууд нь амьдралын утга учир болон өдөр тутмын эдрээтэй ертөнцөд хэрхэн сайхан амьдрах тухай өгүүлдэг" гэж тодорхойлсон байдаг.

"Оюун түлхүүр" сургаалыг XIII зууны үед зохиож, бидний үед монгол бичгээр уламжлан ирсэн болохыг судлаачид хэдийнээ судлан тогтоосон билээ. Гэрийн сургалтын үед, хүүхэд уншиж сурсан даруйд буюу цагаан толгой амласны дараа анхлан тус сургаалыг уншуулдаг уламжлал байсан ба үүний талаар академич Ц.Дамдинсүрэн "Оюун түлхүүр болбоос Монголын дотор маш түгээмэл дэлгэрсэн зохиолын нэг болмуй. Гэрээр бичиг сурах багачуудад цагаан толгой заасны дараа Оюун түлхүүрийг уншуулдаг байлаа. Энэ ном болбоос урьд цагт зан суртахууны сурах бичгийн чанартай хэрэглэгдэж байсан бөлгөө" (Дамдинсүрэн, 1959:58) гэсэн бол эрдэмтэн Ш.Чоймаа "Багачууд хүүхдүүд үсэг нүдлэнгүүт нь эзэн богд Чингисийн билиг сургаалыг цээжлүүлдэг байсны ач буянаар монголчуудын олон үеийнхэн эзэн Чингисийн үеийн Их Монгол улсын тухай эртний түүхийг хүүрнэн ярилцаж, уг язгуураа үл умартан ирсэн буй заа." (Чоймаа, 2002:101) хэмээсэн нь бий.

Ийнхүү "Оюун түлхүүр" сургаалыг гэрийн сургалтад хэрэглэдэг байсан шалтгааныг бид тус зохиол дахь хүний дотоод сэтгэлээ таньж мэдэх, хэрэглэх, ойлгох, удирдан залах, ингэснээр бусдыг болон хорвоо ертөнцийг таних тухай агуулга болоод бусад агуулгатай холбон үзэж буй бөгөөд үүнийг сэтгэл судлал, тархи судлал, социологи хийгээд боловсролын салбарын дундын шинжтэй, өрнө дахинаа XIX зуунаас судлагдаж эхэлсэн "Сэтгэл хөдлөлийн оюун ухаан" (Emotional Intelligence)-тай холбон тайлбарлах боломжтой хэмээн таамаглаж байна. Сэтгэл хөдлөлийн оюун ухааны ач холбогдлын тухай "Positive Psychology" сэтгүүлийн №18-д "Сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь танин мэдэхүй ба сэтгэл хөдлөлийн уулзвар бөгөөд бидний тэсвэр тэвчээр, урам зориг, өрөвдөх сэтгэл, стрессийг удирдах, харилцах чадварыг хөнгөвчлөх, олон янзын нийгмийн нөхцөл байдал, зөрчилдөөнийг ойлгож, зохицуулах чадварыг дэмждэг. Үүнийг хөгжүүлбэл илүү сэтгэл хангалуун, аз жаргалтай амьдралыг мэдрэх боломжтой" (Шнайдер, 2003: 109) гэж тайлбарласан байна.

## 2. Судалгааны арга зүй

Судалгаанд академич Ц.Дамдинсүрэнгийн “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой” бүтээлд хэвлүүлсэн “Оюун түлхүүр” сургаалын хувилбарыг дараах гурван гар бичмэлтэй харьцуулж, текст анализын аргаар задлан шинжилгээ хийв.

1.МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэлний тэнхимийн багш, хэл шинжлэлийн ухааны доктор, дэд профессор Д.Эрдэнэсангийн хувийн номын санд хадгалагдаж буй “oyun tülkigür nerete šastir orušibai” нэрт, 26.5x13 хэмжээтэй муутуу цаасан дээр бийрээр бичсэн, 19 нүүр, дэвтэрчилсэн гар бичмэл;

2.ШУА-ийн ХЗХ-д хадгалагдаж буй М80(215) дугаартай, “činggis boyda-yin nomlaysan oyun-u tülükügür orušibai” нэртэй, 20.5x9.5 хэмжээтэй хятад муутуу цаасан дээр хулсан үзгээр бичсэн, 16 нүүр (адгаас дутуу), сударчилсан гар бичмэл;

3.Ховд аймгийн Манхан сумын Төгрөгийн хүрээний Раашгонзэглин хийд ба Америкийн Монгол судлалын төвд хадгалагдаж буй “oyouni töülküür kemekü šastir orušibui” нэртэй, 28.3x8.8 хэмжээтэй муутуу цаасан дээр тод үсгээр, бийрээр бичсэн, 14 нүүр, сударчилсан гар бичмэл  
Мөн өдгөө сургалтад хэрэглэгдэж буй бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж (2019), сурах бичгүүдэд текст анализын аргаар задлан шинжилгээ хийв.

## 3. Судалгааны хэсэг

“Оюун түлхүүр” сургаалын зохиол нь монголд өргөн тархан дэлгэрсний тул судлагдсан байдал ч мөн багагүй байна. Хэдий үед зохиогдсон талаарх эрдэмтдийн саналыг дурдахын урьд хэдий үеэс хэвлэгдэж эхэлсэн болохыг хайваас тус сургаалын зохиолын олон нийтэд хамгийн өргөн тархсан хувилбарыг эмхэтгэн хэвлүүлсэн, академич Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой” бүтээлд “Дурсгалт бичгийг хорголжин бараар хэвлэх ажил Монголын автономит засгийн үеэс эрдэмтэн Цэвээний удирдлагаар эхэлжээ. Чингээд сургуульд үзүүлэх зорилгоор Чингисийн 2 загалын тууж, Чингисийн дурсгалын түүвэр, Оюун түлхүүр, Цаасан шувууны үлгэр зэрэг нэлээд дурсгалт бичгийг хэвлэжээ” (Дамдинсүрэн, 1959: 6-7) хэмээн дурдсан байна.

Тус сургаалын зохиогдсон цаг хугацааг XIII зуун хэмээн олонх судлаач үздэг байна. Тухайлбал,

-“Оюун түлхүүр” хэмээх энэхүү сургаалын зохиол XIII зууны үеэс уламжилж ирсэн бөгөөд энэхүү зохиолын нэг хэсгийг Чингис хаан өөрөө бичсэн биш юмаа гэхэд тэр цагт зохиогдсон юм хэмээн Да багш үзсэн буй... Оюун түлхүүр бол бүр XIII зууны үеэс бичгээр уламжлагдсан монгол сургаалын зохиолын чухал цоморлог болно. Үг зохиолын агуулгыг нягтлан үзвээс XIII зууны үеийн Монголчуудын төр ёсны зохиолын дурсгал бичиг “Их засаг” хэмээх хууль зүйн бичиг, эзэн Чингисийн зарлиг сургаал буюу “Чингисийн билиг” зэрэг зохиолын гол гол санааг уламжлан авч улмаар XIV зууны үеэс монгол утга зохиолд нэвтрэн орж ирсэн “Рашааны дусал”, “Субашида” зэрэг хос ёсны сургаалын нөлөө тусгалаар баяжиж ирсэн байдал ажиглагдаж байна.” (Дамдинсүрэн, 1959: 58-59)

-“Үнэхээр энэ зохиол эхлэхдээ: “Эртний Богд Чингисийн зохиосон шастирыг сануулахын учир...” гэж буй нь энэ сургаалыг Чингис хаан зохиосон юм гэдгийг шууд хэлсэн байгаа нь энэхүү зохиол ямартай ч Чингис хааны үеэс үүдэлтэйг харуулж байнам.” (Лочин, 2019: 360)

-“1989 онд Юн Сиян, Дэсрайжав нар “Оюун түлхүүр”-ийг XIII зуунаас уламжилж ирсэн сургаал гэсэн ба тэр нь тусгайлан суртал боловсрол, сүс зоригийг боловсруулах сургаал захиа болно гэж үзжээ” (Сарангуагийн эшилснээс, 2001: 104).

-“1994 онд До.Дэлгэрсан “Оюун түлхүүр” бол XIII зууны үеэс уламжлагдан ирсэн сургаал шүлгийн түүвэр болно гэж үзсэн” (Сарангуагийн эшилснээс, 2001: 104) зэргээр адил үзэлтэй байдаг бол

-Эрдэмтэн Д.Цэрэнсодном “Үнэндээ “үүнээс үлэмж судар дор номлогдсон нь” гэсэн 293-р мөрөөс хойших хэсэг бол сүүлд нэмсэн буюу засаж өөрчилсөн байдалтай юм. Ялангуяа энэ хэсэгт орсон зарим шүлэг нь өмнөх хэсэгтэйгээ давхардсан хийгээд “Панчатантра”, “Субашид”

зэрэг зохиолын орчуулгаас найруулж авч орчуулсан зүйл ч ажиглагдаж байна. Ийм учраас “Оюун түлхүүр” бол угтаа хос ёсны сургаалын зохиолын нөлөөгөөр XIV зууны эхэн үед гарсан байж болох боловч олон үеийн турш бичээч нарын гар дамжиж ирэхдээ үлэмж өөрчлөгдөж шинэчлэгдсээр ирсэн зохиол болно” (Цэрэнсодном, 2002: 197) хэмээн яльгүй ялгаатайгаар үзсэн бол,

-Зөвлөлтийн монголч эрдэмтэн Г.И.Михайлов “Оюун түлхүүр”-ийн зохиомж, бүтэц, үгийн сангийн бүрэлдэхүүнийг хянаж үзээд XVII-XVIII зууны үед зохиогдсон” (Михайлов, 1969: 69) гэж үзсэнээрээ бусад судлаачдаас ялгаатай байна.

Тус сургаалын зохиолын судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан судлаачид бол академич Ц.Дамдинсүрэн, ОХУ-ын эрдэмтэн Н.С.Яхонтова, ӨМӨЗО-ы эрдэмтэн Сарангуа нар юм. Академич Ц.Дамдинсүрэн “Оюун түлхүүрийг хэвлэхдээ Улаанбаатарын 2 удаагийн хэвлэлийг гол болгоод, таван зүйлийн гар бичмэлтэй нийлүүлэн хянаж бэлтгэв. Оюун түлхүүр болбоос Монголын дотор маш түгээмэл дэлгэрсэн зохиолын нэг болмуй. Гэрээр бичиг сурах багачуудад цагаан толгой заасны дараа Оюун түлхүүрийг уншуулдаг байлаа. Энэ ном болбоос урьд цагт зан суртахууны сурах бичгийн чанартай хэрэглэгдэж байсан бөлгөө. Үүнийг Чингис Хаан зохиосон гэж уг зохиолын дотор дурдсан баймуй. Үнэхээр үүний зарим хэсэг нь Чингисийн билиг сургаалтай холбоотой ажгуу. Гэвч оюун түлхүүр бүхлээр Чингисийн билиг сургаалаас гаралтай зохиол бус бололтой. Ажиглаваас уг зохиол, 2, 3 хэсэг хэсгээс бүтжээ, эхний хэсэг нь үнэхээр Чингисийн билиг сургаал мөн бололтой” (Дамдинсүрэн 1959: 58) гээд цааш нь тус сургаалыг 3 хэсэгт ангилаад, эхний хэсгийг Чингисийн билиг сургаал гэж үзэхдээ, шарын шашин дэлгэрсэн цагаас хойш нэмэгдэн орсон гэж таамаглаж буй мөрүүдийг тусад нь дурдан, 2 ба 3-р хэсгүүдийг тайлбарлахдаа XIV зууны үед зохиогдсон Төвөд сургаал “Субашид”-тай харьцуулсан байна.

Тэгвэл судлаач Н.С.Яхонтова, Сарангуа нар өөр өөрийн улсад буй “Оюун түлхүүр” сургаалын зохиолын гар бичмэлүүдийг цуглуулж, бүртгэн, хооронд нь харьцуулан ажиглах судалгааг чамгүй хийсэн байна. Тухайлбал, судлаач Сарангуа “Оюун түлхүүр”-ийн тухай ажиглалт өгүүлэлдээ “Одоо зөвхөн гарт байгаа 12 зүйлийн бичмэлийг тус тусад нь товч танилцуулж олны хүртээмж болгоё. 1. “Оюун түлхүүр” хэмээгдэх оршив, 2. Чингис Богд хааны байгуулсан Оюуны түлхүүр нэрт шастир, 3. Оюун түлхүүрийн судар оршив, 4. “Оюун түлхүүр” нэрт судар оршвой, 5. Эртний мэргэдийн сургаал, 6. “Оюуны түлхүүр” хэмээх бичиг, 7. Оюун түлхүүр нэг сургаал оршив, 8. “Оюун түлхүүр” нэрт шастир, 9. Оюун түлхүүр, 10. Чингис богдын зохиосон “Оюун түлхүүр” нэрт шастир оршив, 11. Эртний сургаал, 12. Богд Чингис хааны сургаал” (Яхонтова, 2001:105-106) гээд тус бүрийн дугаар, цаасны хэмжээ, материал зэргийг дурдаад, эдгээрийг “хуулагч тодорхой байгаа, хуулсан цаг үе нь тодорхой, төгсгөлд нь “Оюун түлхүүр” нэр илэрсэн, дээрх 3 төрөлд багтахгүй” гэсэн 4 бүлэгт хуваан ангилснаас гадна хамгийн эртний гэж таамаглаж буй бичмэлүүдэд ажиглалт хийх, “Чингисийн билиг” сургаалтай харьцуулах зэрэг шинжилгээг хийсэн байна.

ОХУ-ын судлаач Н.С.Яхонтова тус сургаалын талаар 1992 онд “Оюун түлхүүр”-ийн ойрад орчуулга” Түрэг, монгол бичгийн дурсгал. (Эх бичиг судлал ба соёлын талууд), 1994 онд “Оюун түлхүүр”-ийн дүгнэлт, тайлбар” (XIX-XX зууны эхэн үеийн уугуул монголчуудын архиваас), 1998 онд “Нэргүй сургаалуудын цуглуулга” (Ц.Дамдинсүрэнгийн мэндэлсний 90 жилийн ойд зориулав), 2000 онд “Оюун түлхүүр”: Санкт-Петербургийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн гар бичмэлүүдэд үндэслэсэн текст ба орчуулга” гэсэн өгүүллүүдийг бичиж хэвлүүлсэн байдаг. Эдгээртээ голчлон академич Ц.Дамдинсүрэнгийн тайлбараас эшлээд дээр дурдсан сан хөмрөгт хадгалагдаж буй 24 гар бичмэлд хийсэн ажиглалт судалгаагаа танилцуулжээ. Тухайлбал, “Оюун түлхүүр” сургаалын олон тооны гар бичмэл байдаг нь Монголын уншигчдын дунд тус зохиол хэр нэр хүндтэй байсныг гэрчилнэ. ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн Санкт-Петербург дахь салбарын гар бичмэлийн санд л гэхэд монгол хэлээр 24, ойрад хэлээр нэг гар бичмэл хадгалагдаж байгаа бөгөөд бүгдийнх нь гарчигт “oyun tülkigür” гэсэн үг бий” (Яхонтова, 2000:72) гээд цааш нь гар бичмэлүүдийн онцлогийг танилцуулж, академич Ц.Дамдинсүрэнгийн хэвлүүлсэн эх хийгээд бусад гар бичмэлүүдэд байх мөр, эс байх мөр зэргийг англи орчуулгын хамт дурдаж, төгсгөлд нь MS C298 дугаартай гар бичмэлийг галиглаад, мөн англи руу орчуулжээ.

“Оюун түлхүүр” сургаалын манай улс дахь сүүлийн үеийн судалгаанаас дурдвал эрдэмтэн С.Дулам 2014 онд “Төвд судлал” Боть 3-т “Сажа Бандид Гунгаажалцаны намтар, бүтээлд холбогдох түүх домог ба бодот үнэн, “Субашид”, “Оюун түлхүүр”-ийн харилцаа холбоо” гэсэн өгүүллийг хэвлүүлсэн бол эрдэмтэн Ш.Чоймаа 2002 онд “Их эзэн Чингис хааны билиг сургаалыг судлах асуудалд” хэмээх өгүүлэлдээ “Оюун түлхүүр” сургаалын талаар цухас дурдаад, 2011 онд “Монгол ёс заншил, уламжлалт ухаанаа заан сургагч нарт тус дэм” номдоо тус сургаалын тоймыг товч өгүүлээд, цааш “Миний бие, энэхүү номыг бэлдэхдээ, академич Ц.Дамдинсүрэн гуайн “Монгол уран зохиолын дээж зуун билиг”-т хэвлүүлсэн “Оюун түлхүүр” сургаалыг үндэс болгоод, Н.С.Яхонтовагийн хэвлүүлсэн тод бичгийн эх зэргийг зохих хэмжээнд харьцуулав. Өнөөгийн залууст ойлгомжтой болгох үүднээс, кирилл үсгийн хөрвүүлэг дэх зарим үг хэллэг, хэл зүйн хэлбэрийн өдгөөчилсөн тайлбарыг хаалтад бичлээ” гэсэн байдаг. Бид энэхүү судалгааны ажилдаа эрдэмтэн Ш.Чоймаагийн тодотсон тус эхийг ашиглав.

Тус сургаалын зохиолыг ёс суртахууны сурах бичгийн үүргээр, мөн түшмэл нарын гарын авлага болгох зэргээр хэрэглэдэг байсан тухай академич Ц.Дамдинсүрэн дурдсан байдаг агаад энэ талаас нь ШУА-ийн философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор М.Золзаяа “Монголын ёс зүйн сэтгэлгээний түүхэнд холбогдох гар бичмэлийн нэгэн хувилбарын тухай”, МУБИС-НХУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн магистр Т.Даариймаа “Оюун түлхүүр” шастир дахь ёс суртахууны философийн асуудалд” зэрэг судалгааны ажлуудыг хийсэн байна.

#### 4. Судалгааны үр дүн

##### 4.1. Оюуныг нээгч “Оюун түлхүүр” сургаалын гурван хувилбарын агуулгын харьцуулалт

Энэхүү судалгааны ажлаараа бид “Оюун түлхүүр” сургаалын зохиолын гурван гар бичмэлийг академич Ц.Дамдинсүрэнгийн эмхэтгэн хэвлүүлсэн хувилбартай агуулгаар нь харьцуулав. Судрын мөрийг тоолон гаргахад бэрх тул нийт үгийн тоогоор харьцуулбаас “oyun tulkigür nerete šastir orusibai” зохиол 1751, “činggis boyda-yin nomlaysan oyun-u tülükügür orušibai” зохиол 1467, “oyouni töülküür kemekü šastir orušibui” зохиол 2142 үгтэй бол “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой” бүтээл дэх “Оюун түлхүүр” (доош ОТ гэж товчлов) зохиол 2072 үгтэй байна.

1-р хувилбар (oyun tulkigür nerete šastir orusibai) хэдий гүйцэд боловч цаас нь ноорсны улмаас төгсгөлийн мөрүүдийг гарган унших боломжгүй болсон байна. Иймийн тул үгийн тоо нь академич Ц.Дамдинсүрэнгийн эмхэтгэсэн хувилбараас даруй 300 орчмоор дутуу байна. Мөн ОТ-т буй боловч 1-р хувилбарт огт гараагүй агуулга, утга бүхий

*“...Арслан мэт ноёдыг*

*Барс мэт түшмэд дагах.*

*Барс мэт ноёдыг*

*Ирвэс мэт түшмэд дагах.*

*Ирвэс мэт ноёдыг*

*Чоно мэт түшмэд дагах.*

*Чоно мэт ноёдыг*

*Үнэг мэт түшмэд дагах тул*

*Хамагт зовлон болмуй...”*

*“...Үлэмж сайн ханилсан хүмүүсийг*

*Үнэхээр муу сэтгэлтэй хүмүүс*

*Үзэн ядаж, хуурмаг аргаар эвдрүүлээд*

*Элэглэе гэх мэдэшгүй.*

*Өнгөч зусар аргатай хүн*

*Зөөлөн худал үгээр хууран байж*

*Үнэн санааг аваад*

*Үймтэл муутган хэлэх нь олон буй.*

*Үзэж таньж ханил...”*

“...Эрдмийг хичээн сурваас  
Алдар нэр хаана ч алдаршмуй.  
Гэм эрдэм хоёрыг ялгаж эс мэдсэний үлгэр нь  
Мунхаг ухаант хүн, мэргэдээс дайжаад  
Сармагчин хөтөлсөн хүнийг хүндлэв гэх...” хэмээсэн 3 хэсэг буйгаас гадна “Мигуй хүзүүндээ  
эрхи зүүж” гэсэн мөрөөс хойш 1-р хувилбарыг гүйцээн унших боломжгүйн тул 300 орчим  
үгийн зөрүү гарчээ.

2-р хувилбар (činggis boyda-yin nomlaysan oyun-u tülükügür orušibai) адгаас дутуу болохыг  
“Хэл зохиолын хүрээлэнгийн Монгол бичмэл дармал номын бүртгэл” номын 103-р талд  
дурдсан буй. “Эдүгээгийн энэ цаг лугаа нийлэх тул” хэмээнээс хойших 300 орчим үг байхгүйн  
дээр “Арслан мэт ноёдыг Барс мэт түшмэд дагах” гэснээс үргэлжлээд “Төв ихсийн журмыг  
дагаж явбаас, Түмнийг эхлэх болох” гэх хүртэл 54 орчим мөр, 220 орчим үг байхгүйн тул 600  
орчим үгийн зөрүү гарч байна.

3-р хувилбар (oyouni töülkүүr kemekü šastir orušibui)-т

“...Их эрдэмтэйгээр омоггүй эелдэг зөөлөн  
Өчүүхэн эрдэмтэн бээр омог их бардам хатуу.  
Их далай мэлмийж байх  
Өчүүхэн ус хоржигнож урсах түүнчлэн болой.  
“...Бас хотол төгссөн дахинаа учрах хойд нутгийг тэргүүлж  
Дэлгэрүүлэн засах сайн хөвгүүн төрөх.” зэрэг ОТ-т эс байх утга санаа бүхий мөрүүд буйн тул  
3-р хувилбар нь 70 орчим мөрөөр ОТ-ээс их байна.

“Оюун түлхүүр” сургаалын зохиолын хэсгүүдийн тухайд 1-р хувилбарт, “Чингис богдын  
байгуулсан шастир үүгээр Шашин төр энхээр тогтох болтугай.” гэсэн мөрөөр, 2-р хувилбарт  
“Чингис Богдын байгуулсан шастир үүнд Шашин төр энхээр тогтох болтугай.” гэсэн мөрөөр,  
3-р хувилбарт “Ашдын хүнс Амгалангийн дээд бодь мөр нь лам гурван эрдэнэ.” гэсэн мөрөөр  
эхний хэсгүүд төгсөж байна. Удаах хэсэг нь 1-р хувилбарт “Чингис богдын номлосон оюун  
түлхүүр нэрт шастир төгсөв.” гэсэн мөрөөр, 2-р хувилбар дутуу тул 1-р бүлгээс цааш  
байхгүй, 3-р хувилбарт “Чин сайн эрдэмт хүн болбоос Чоно хонь хоёрыг нэгэн онгоцонд услах.”  
гэсэн мөрөөр төгсөж байна. 1-р хувилбарын дээр дурдсан 2 мөрийн доор бүлэг хаах цэгүүд  
байх ба түүнээс хойш сургаал бүрэн дуустал нэг хэсэг явж буй тул нийт 3 хэсэгтэй гэж үзэж  
болохоор байна. Харин 3-р хувилбарт “Чингис Богдын байгуулсан шастир үүгээр Шашин төр  
энхээр тогтох болтугай.” гэсэн мөрөөр ахин нэг хэсэг төгсөж буйн тул нийт 4 хэсэгтэй мэт.

Тэгвэл академич Ц.Дамдинсүрэн “Оюун түлхүүр” сургаалын зохиолыг 3 хэсэгтэй  
хэмээгээд, “Шударга үгийн сургаал үүнээс элдэв жаргал үүсэх болтугай.” гэсэн мөрөөр эхний,  
“Чингис Богдын зохиосон сургаал үүгээр Шашин төр хоёр энх амгалан тогтох болтугай.”  
гэсэн мөрөөр удаах, “Оюун түлхүүр нэртэй шастир төгсвэй.” гэсэн мөрөөр 3 дахь хэсэг  
дуусаж буй хэмээн тайлбарласан байдаг. Энд 2 дахь хэсгийг төгсгөн буй мөр бидний судлан  
буй 3 хувилбар тус бүрд аль нэг хэсгийг төгсгөж буйгаараа адил байна. Харин Ойрад аман  
аялгууг тэмдэглэсэн Тод үсгийн бичмэл буюу 3-р хувилбар дахь хэсгийн хуваарь бусдаасаа  
нэлээн ялгаатай аж.

Хувилбар тус бүрийн эхэн хийгээд сүүлийн мөрүүдийг ажиглаваас 3 хувилбар “Лам  
гурван эрдэнэд итгэмүй” гэсэн мөрөөр эхэлж буйгаараа адил бол Ц.Дамдинсүрэнгийн  
эмхэтгэсэн “Оюун түлхүүр”-т “Дээд лам гурван эрдэнэд итгэмүй” хэмээн эхэлсэн байна. 1-р  
хувилбар “Өлзий хутаг ориших болтугай. Ум ма ни бад мэ хум” гэсэн мөрөөр, 2-р хувилбар  
дутуу тул төгсгөлийг мэдэх боломжгүй, 3-р хувилбар Самгардаар “Сарва мангалам” буюу  
“Өлзий хутаг ориших болтугай” хэмээх мөрөөр төгссөн бол ОТ-т энэ мэт төгсгөлийн үг байхгүй  
байна.

**4.2. Оюуныг нээгч “Оюун түлхүүр” сургаалын агуулга ба сэтгэл хөдлөлийн оюун  
ухааны чадварууд**

Кембрижийн Их Сургуулиас эрхлэн гаргасан “Оюун ухааны гарын авлага” (The Cambridge Handbook of Intelligence) номд бичсэнээр “Сэтгэл хөдлөлийн оюун ухаан” гэсэн нэр томъёо нь анх 1990 онд сэтгэл судлалын ном зохиолуудад бичигдэх болсон ба “өөрийн болон бусдын мэдрэмж, сэтгэл хөдлөлийг хянах, тэдгээрийг хооронд нь ялган салгаж, өөрийн сэтгэхүй хийгээд үйлдлийг удирдахад ашиглах чадвар” (Саловэй, Маер, 1990:189) гэж тодорхойлсон байдаг. Тус ойлголт олон нийтэд тархаж, сэтгэл хөдлөлийн салбарын практик судалгаа өргөжин тэлж, өргөн хүрээний нэр томъёо болсон тул зарим судлаач сэтгэл хөдлөлийн оюун ухааны хандлагуудыг “чадварын” загвар ба “холимог” загвар гэж ангилан үзсэн. (Маер, Саловэй, Карусо, 2000)

Сэтгэл хөдлөлийн оюун ухааны гол суурь загвар болох “Чадварын” загвар (ability model)-ыг 1990 онд Саловэй, Маер (Salovey, Mayer) нар санал болгосон. Энэхүү загвар нь сэтгэл хөдлөлийн оюун ухааныг өөрийн болон бусдын талаарх цугларсан мэдээллийг үр өгөөжтэйгөөр боловсруулах чадвар гэж үздэг. Сэтгэл хөдлөлийг мэдрэх, илэрхийлэх, зохицуулах, хэрэглэх зэрэг үйлүүд нь сэтгэхүй хийгээд урам зоригийг нэмэгдүүлдэг, хүний сэтгэл хөдлөлийн оюун ухааныг бүрдүүлдэг сэтгэцийн тодорхой үйл явц гэж тодорхойлсон. Өнөө үед хамгийн өргөн тархсан сэтгэл хөдлөлийн оюун ухааны “чадварын” загвар нь холбогдох чадваруудыг дөрвөн түвшинд ангилж үздэг. Эдгээр нь:

1. Сэтгэл хөдлөлийг таньж ухамсарлах
2. Бодлыг хөнгөвчлөхийн тулд сэтгэл хөдлөлийг хэрэглэх
3. Сэтгэл хөдлөлийг ойлгох
4. Сэтгэл хөдлөлийг удирдах (Саловэй, Маер, 1997) болно.

2016 онд Маер, Карусо, Саловэй (Mayer, Caruso, Salovey) нар дээрх ангиллыг засан сайжруулсан. Үүнд, 4 түвшин тус бүр нь хялбараас хүнд рүү чиглэсэн, хөгжлийн явцад олж авдаг, хоорондоо холбоо бүхий чадваруудаас бүрдэнэ. Сэтгэл хөдлөлийг таньж ухамсарлах нь сэтгэл хөдлөлийг зориудаар, нягт нямбай зохицуулахаас илүү энгийн чадваруудыг агуулдаг гэж үздэг.

–“Сэтгэл хөдлөлийг таньж ухамсарлах” хэмээх эхний түвшинд тэдгээрийг таних, илэрхийлэх чадварууд багтана. Тухайлбал, хэн нэгний мэдэрсэн сэтгэл хөдлөлийн төлөв байдлыг ялгаж салгах, үнэн зөв тодорхойлох.

–“Бодлыг хөнгөвчлөхийн тулд сэтгэл хөдлөлийг хэрэглэх” хэмээх хоёр дахь түвшинд тухайн мэдээлэлд анхаарлаа төвлөрүүлэхэд ямар сэтгэл хөдлөлийн байдал хамгийн үр дүнтэй болохыг мэдэх, шүүмжлэлт сэтгэлгээгээр шийдвэр гаргах чадварыг түргэсгэхийн тулд тохиромжтой сэтгэл хөдлөлийг бий болгох зэрэг багтана.

–“Сэтгэл хөдлөлийг ойлгох” хэмээх гурав дахь түвшин нь сэтгэл хөдлөлийн шалтгаан, харилцан хамаарлыг ойлгох тухай юм. Атаархах, шаралхах гэх мэт хоорондоо төстэй, ээдрээтэй сэтгэл хөдлөлийг ойлгох чадварыг багтаадаг.

–“Сэтгэл хөдлөлийг удирдах” хэмээх дөрөв дэх түвшин нь тодорхой зорилгод хүрэхийн тулд сэтгэл хөдлөлөө үр дүнтэй удирдахыг хэлнэ. Эхний хувилбартай харьцуулахад үзэл баримтлалын хувьд бүрэн бүтэн хэвээр боловч Маер, Саловэй, Карусо (2016) нар бүлэг тус бүрийн зарим чадварыг хоёр буюу түүнээс дээш тодорхой чадварт хувааж, ашиглах, ойлгох (2, 3) түвшнүүдэд шинэ чадвар нэмсэн. (2020:709-710)

Мөн тус номд өгүүлснээр “Өгүүлэн буй “чадварын загвар” нь сэтгэл хөдлөлийн тодорхой талууд (жишээ нь, нүүрний хувирал, бие махбодын мэдрэмж) нь бүх нийтийн шинж чанартай байдаг (түгээмэл) гэсэн үндэслэл дээр үндэслэдэг.

Саловэй, Маер нар сэтгэл хөдлөлийн оюун ухааны чадварын загварыг танилцуулсны дараа судлаачид бусад хэд хэдэн загварыг санал болгосон. Эдгээр загвар нь сэтгэл хөдлөлийг удирдахын тулд сэтгэхүйг удирдах, сэтгэхүйг удирдахын тулд сэтгэл хөдлөлийг ашиглах чадвар төдийгүй хувь хүний зан чанарын шинжүүдийг багтаан сэтгэл хөдлөлийн оюун ухааны бүрэлдэхүүн хэсгүүдийг өргөжүүлсэн. Дөрвөн түвшинд тодорхойлсон үндсэн чадваруудын дор хаяж нэг (жишээ нь, сэтгэл хөдлөлийг зохицуулах)-ийг, мөн чадвартай холбоогүй чанарууд (жишээ нь, аз жаргал эсвэл өөдрөг үзэл гэх мэт)-ыг багтаасан байдаг тул сэтгэл хөдлөлийн оюун ухааны эдгээр ойлголтыг ихэвчлэн “холимог” загвар (mixed model) гэж нэрлэдэг (Маер нар, 2000). Нэг алдартай загвар болох сэтгэл хөдлөл-нийгмийн оюун ухааны Бар-Оны загвар

(Bar-On model) нь хувь хүний гүйцэтгэлийг хүний өөрийн дотоод болон хүн хоорондын олон чадамжийн үр дагавар гэж тайлбарладаг (Бар-Он, 1997, 2006). Эдгээр нь Салови, Майер нарын дөрвөн түвшин бүхий загварт тодорхойлсон хэд хэдэн чадвараас гадна өөдрөг үзэл, өөрийгөө үнэлэх, өдөөгчийг хянах зэрэг олон төрлийн шинжийг агуулдаг.

Мөн Петридэс ба Фурнхам (Petrides, Furnham) (2001, 2003) нарын санал болгосон өөр нэг алдартай загвар нь “сэтгэл хөдлөлийн оюун ухааны шинж чанар”-ыг “өөрийгөө тайлагнаснаар үнэлдэг сэтгэл хөдлөлтэй холбоотой өөрийгөө ойлгох чадвар, зан чанарын нэгдэл” гэж тодорхойлсон (Петридэс, Фурнхам, 2003:40). Энэхүү бүтэц нь дасан зохицох чадвар, өөртөө итгэлтэй байдал, өөрийгөө үнэлэх зэрэг шинж чанарыг агуулдаг (Петридэс, Фурнхам, 2001)” (2020: 713-714). Тус судалгааны ажилд бид сэтгэл хөдлөлийн оюун ухааны суурь, үндсэн загвар болох “чадварын” загварыг харьцуулалтын үндэс болгон сонгож, дээр дурдсан дурдсан 4 түвшин, тэдгээрт хамаарах сэтгэл хөдлөлийн чадваруудыг “Оюун түлхүүр” сургаалын агуулгатай харгалзуулан ажиглахыг зорьсон тул “чадварын” загварыг доор хүснэгтээр дэлгэрэнгүй харуулав.

*Хүснэгт 1. Сэтгэл хөдлөлийн оюун ухааны чадварын загвар*

| №          | “Чадварын” загварын 4 түвшин ба тэдгээрт багтах сэтгэл хөдлөлийн чадварууд                                         |
|------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>IV</b>  | <b>Сэтгэл хөдлөлийг удирдах/Managing emotions</b>                                                                  |
| 1          | Хүссэн үр дүндээ хүрэхийн тулд бусдын сэтгэл хөдлөлийг үр дүнтэйгээр удирдах                                       |
| 2          | Хүссэн үр дүндээ хүрэхийн тулд өөрийн сэтгэл хөдлөлийг үр дүнтэйгээр удирдах                                       |
| 3          | Сэтгэл хөдлөл бүхий хариу үйлдлийг дэмжих, бууруулах, нэмэгдүүлэх аргыг тооцоолох                                  |
| 4          | Үндэслэлийг нь тогтоох үүднээс сэтгэл хөдлөлийн хариу үйлдлүүдээ хянах                                             |
| 5          | Хэрвээ ашигтай бол сэтгэл хөдлөлөөр оролцох, үгүй бол оролцохгүй байх                                              |
| 6          | Таатай болон таагүй мэдрэмжүүд (шаардлагатай тохиолдолд тэдгээрээр дамжиж буй мэдээлэлд)-д нээлттэй байх           |
| <b>III</b> | <b>Сэтгэл хөдлөлийг ойлгох/Understanding emotions</b>                                                              |
| 1          | Сэтгэл хөдлөлийг дүгнэхдээ соёлын ялгааг хүлээн зөвшөөрөх <sup>c</sup>                                             |
| 2          | Ирээдүйд эсвэл ямар нэг нөхцөлд хүнд ямар мэдрэмж төрж болохыг тооцоолох (сэтгэл хөдлөлийг таамаглах) <sup>c</sup> |
| 3          | Сэтгэл хөдлөлийн шилжилтийг таних (уур уцаараас сэтгэл ханамж гэх мэт)                                             |
| 4          | Нарийн төвөгтэй, холимог сэтгэл хөдлөлийг ойлгох                                                                   |
| 5          | Зан байдал, сэтгэл хөдлөлийг ялгах <sup>c</sup>                                                                    |
| 6          | Сэтгэл хөдлөлийг өдөөх магадлалтай нөхцөл байдлыг үнэлж дүгнэх <sup>c</sup>                                        |
| 7          | Сэтгэл хөдлөлийн урьдач нөхцөл, учир шалтгаан, үр дагаврыг тодорхойлох                                             |
| 8          | Сэтгэл хөдлөлийг нэрлэж, тэдгээрийн хоорондын харилцааг танин мэдэх                                                |
| <b>II</b>  | <b>Бодлыг хөнгөвчлөхийн тулд сэтгэл хөдлөлийг хэрэглэх/Facilitating thought using emotions</b>                     |
| 1          | Одоогийн сэтгэл хөдлөлийн байдал нь танин мэдэхүйг хэрхэн хөнгөвчлөхөд тулгуурлан асуудлыг сонгох                  |
| 2          | Өөр өөр танин мэдэхүйн хэтийн төлөвийг бий болгохын тулд сэтгэлийн хөдлөлийн өөрчлөлтийг ашиглах                   |
| 3          | Одоо байгаа мэдрэмжид анхаарал хандуулж, сэтгэн бодохыг урьтал болгох                                              |

|                                                                    |                                                                                                 |
|--------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------|
| 4                                                                  | Өөр хүний туршлагатай холбон сэтгэл хөдлөлийг бий болгох <sup>c</sup>                           |
| 5                                                                  | Эргэцүүлэл хийгээд санах ойд туслах сэтгэл хөдлөлийг бий болгох                                 |
| <b>I</b>                                                           | <b>Сэтгэл хөдлөлийг таньж ухамсарлах/Perceiving emotion</b>                                     |
| 1                                                                  | Хуурамч эсвэл шударга бус сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тодорхойлох <sup>b</sup>                |
| 2                                                                  | Сэтгэл хөдлөлийн илэрхийллийг зөв, буруугаар нь ялгах <sup>b</sup>                              |
| 3                                                                  | Хам сэдэв, соёлоос хамааран сэтгэл хөдлөл хэрхэн илэрдгийг ойлгох <sup>c</sup>                  |
| 4                                                                  | Хүссэн үедээ сэтгэл хөдлөлөө үнэн зөв илэрхийлэх                                                |
| 5                                                                  | Хүрээлэн буй орчин, дүрслэх урлаг, дуу хөгжим дэх сэтгэл хөдлөлийн агуулгыг мэдрэх <sup>b</sup> |
| 6                                                                  | Хүмүүсийн сэтгэл хөдлөлийг авианы дохио, нүүрний хувирал, хэл яриа, зан авираар нь таних        |
| 7                                                                  | Өөрийн биеийн байдал, мэдрэмж, бодолтой холбогдох сэтгэл хөдлөлийг тодорхойлох                  |
| <i>b - Анхны хувилбар дахь чадварыг хуваахад гарч ирсэн чадвар</i> |                                                                                                 |
| <i>c - 2016 онд шинээр нэмэгдсэн чадвар</i>                        |                                                                                                 |

“Оюун түлхүүр” сургаалын зохиолын дээр дурдсан хувилбаруудаас эрдэмтэн Ш.Чоймаагийн академич Ц.Дамдинсүрэн гуайн эмхэтгэснийг тодлон засварласан хувилбарыг бид судалгаандаа ашиглав. Тус зохиолоос сэтгэл хөдлөлийн оюун ухааны “чадварын” загварыг өгүүлсэн агуулга бүхий мөрүүдийг ялган, түүнээс өөр агуулга бүхий мөрүүдийг:

-Оюун ухааны өөр нэгэн төрөл болох нийгмийн оюун ухаан (social intelligence)-ыг өгүүлсэн,

-Академич Ц.Дамдинсүрэнгийн тус зохиолыг ёс суртахууны сурах бичгийн үүргээр ашигладаг байсныг дурдсан тайлбарт үндэслэн ёс зүйн агуулгатай,

-Судлаачдын тус зохиолд сүүлд нэмэгдсэн, шарын шашны агуулга бүхий мөрүүд цөөнгүй бий гэж үздэг тайлбарт үндэслэн шашны агуулгатай,

-“Цувж явсан барсаас цуглаж суусан шаазгай дээр” гэх зэргийн өдгөө зүйр үг, хэлц үг болон үлдсэн буюу номлол тунхаглалын шинжтэй мөрүүд хэмээн ангилж үзэв. *Хүснэгт 2.*

Ингэхэд сэтгэл хөдлөлийн оюун ухааны “чадварын” загвартай адил агуулга бүхий 201 мөр буюу зохиолын 45.7%, номлол, тунхаглалын шинжтэй мөр 137 буюу зохиолын 31.1%, шашны агуулгатай 40 мөр буюу зохиолын 9.1%, нийгмийн оюун ухааныг өгүүлсэн 31 мөр буюу зохиолын 7%, ёс зүйн агуулгатай мөр 17 буюу зохиолын 3.9%, тайлбар сэлт болох мөр 14 буюу зохиолын 3.2%-ийг тус тус эзэлж байна.

*Хүснэгт 2. Оюун түлхүүр зохиолын агуулгын анализ*

| № | Агуулгын ангилал                                                  | Мөрийн тоо |
|---|-------------------------------------------------------------------|------------|
| 1 | EI буюу сэтгэл хөдлөлийн оюун ухааны “чадварын” загварыг өгүүлсэн | 201        |
| 2 | Номлол, тунхаглалын шинжтэй                                       | 137        |
| 3 | Шашны агуулгатай                                                  | 40         |
| 4 | SI буюу нийгмийн оюун ухааныг өгүүлсэн                            | 31         |
| 5 | Ёс зүйн агуулгатай                                                | 17         |
| 6 | Тайлбар сэлтийн шинжтэй                                           | 14         |
|   | <b>Нийт</b>                                                       | <b>440</b> |

Бидний анхаарлаа хандуулж буй сэтгэл хөдлөлийн оюун ухааны “чадварын” загварыг өгүүлэн заасан мөрүүд зохиолын тал орчим, 45.7 хувийг дангаараа бүрдүүлж байгаагаас харвал “Оюун түлхүүр” сургаалд өөрийн хийгээд бусдын сэтгэл хөдлөлийг танин ухамсарлах, ойлгох,

удирдах тухай чухалчлан өгүүлсэн гэж үзэж болохоор байна. Хүснэгт 1-т үзүүлсэн 26 чадвараас тус сургаалын зохиолд 19 нь өгүүлэгдсэн ба тус бүр хэд хэд буйг доор хүснэгтээр үзүүлэв.

*Хүснэгт 3. Оюун түлхүүр зохиол дахь сэтгэл хөдлөлийн оюун ухааны чадварын түвшин*

| 1-р түвшин  |             | 2-р түвшин  |             | 3-р түвшин  |             | 4-р түвшин  |             |
|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|
| Чадвар      | Илэрсэн тоо | Чадвар      | Илэрсэн тоо | Чадвар      | Илэрсэн тоо | Чадвар      | Илэрсэн тоо |
| 1.1         | 4           | 2.1         | 0           | 3.1         | 0           | 4.1         | 4           |
| 1.2         | 5           | 2.2         | 0           | 3.2         | 1           | 4.2         | 14          |
| 1.3         | 0           | 2.3         | 1           | 3.3         | 0           | 4.3         | 1           |
| 1.4         | 1           | 2.4         | 2           | 3.4         | 0           | 4.4         | 3           |
| 1.5         | 0           | 2.5         | 3           | 3.5         | 1           | 4.5         | 15          |
| 1.6         | 14          |             |             | 3.6         | 0           | 4.6         | 1           |
| 1.7         | 9           |             |             | 3.7         | 3           |             |             |
|             |             |             |             | 3.8         | 2           |             |             |
| <b>Нийт</b> | <b>33</b>   | <b>Нийт</b> | <b>6</b>    | <b>Нийт</b> | <b>7</b>    | <b>Нийт</b> | <b>38</b>   |

Хүснэгтээс харахад сэтгэл хөдлөлийг таних, ухамсарлах түвшний чадвар 33, сэтгэл хөдлөлийг бодлоо хөнгөвчлөхөд ашиглах түвшний чадвар 6, сэтгэл хөдлөлийг ойлгох түвшний чадвар 7, сэтгэл хөдлөлийг удирдах түвшний чадвар 33 байна. “Оюун түлхүүр” сургаалд алив үйл хэрэг, үйл явдлын тухай өгүүлэн сургамжилж буй боловч үйл бүрийн оюун ухааны үндсэн дээр үүссэн явагддаг нь гарцаагүйг санан түүврээ хийсэн болно.

Тухайлбал, 1-р түвшний чадварууд, түүний дотроос 1.6 буюу “хүмүүсийн сэтгэл хөдлөлийг авианы дохио, нүүрний хувирал, хэл яриа, зан авираар нь таних” чадварыг түгээмэл дурджээ. Жишээ нь: “Итгэл үгүй хүнд ямагт зүрхний үгийг бүү хэл.” гэхэд алив хүн ба түүний сэтгэл хөдлөлийг итгэж болох эсэхээр ялган таних тухай сургамжилсан тул 1.6 дахь чадвар хэмээн үзэж байна. 2-р түвшний чадварууд, түүний дотроос 2.5 буюу “эргэцүүлэл хийгээд санах ойд туслах сэтгэл хөдлөлийг бий болгох” чадварыг хэд дурджээ. Жишээ нь: “Үнэхээр барилдсан сайн нөхрийн үгсийг үхтэл бүү март” гэхэд хэн нэгэн хүнийг үнэхээр барилдсан сайн нөхөр мөн эсэхийг эргэцүүлэх, цаашид үгийг нь ой тойндоо санан явахыг сургасны тул 2.5 дахь чадвар хэмээн үзэж байна. 3-р түвшний чадварууд, түүний дотроос 3.8 буюу “сэтгэл хөдлөлийг нэрлэж, тэдгээрийн хоорондын харилцааг танин мэдэх” чадварыг мөн хэд дурджээ. Жишээ нь: “Айх, ичих хоёрыг ажиглаж мэд” гэхэд өөрт төрж буй мэдрэмж хийгээд сэтгэл хөдлөлийг ажиглан танихыг сургамжилсан тул 3.8 дахь чадвар хэмээн үзэж байна. 4-р түвшний чадварууд, түүний дотроос 4.5 буюу “хэрвээ ашигтай байвал сэтгэл хөдлөлөөр оролцох, үгүй бол оролцохгүй байх” чадварыг олон дурджээ. Жишээ нь: “Ер хүн, сайн сайхан үнэн үг, шударга явдлыг хичээн сурагтун.” гэхэд хичээн сурах ёстой зүйлээр сайн сайхан, үнэн хийгээд шударгыг дурдсан буюу алив ашиггүй, тусгүйг үл хийхийг сургасны тул 4.5 дахь чадвар хэмээн үзэж байна.

Дээрхээс харахад 2 ба 3-р түвшний чадварууд 1 ба 4-р түвшний чадваруудтай харьцуулахад харьцангуй цөөн буй нь Дорнын ард түмний бүхэл хийгээд ерөнхийгөөр сэтгэдэг онцлогтой холбоотой хэмээн таамаглаж байна. Мөн утга төгс нэг өгүүлдээр нэгээс илүү 2 ба 3 сэтгэл хөдлөлийн оюун ухааны чадварыг сургамжилсан жишээ олон байна. Тухайлбал, “Үнэн тус хүргэгчдийг муулбаас Тэнгэр үл таалах” гэхэд шашны утга санаа буйн дээр 1.6, 2.4, 4.2 дахь чадваруудыг сургамжилж байна. Юуны урьд үнэн тус хүргэсэн хүн мөн эсэхийг таних буюу “хүмүүсийн сэтгэл хөдлөлийг авианы дохио, нүүрний хувирал, хэл яриа, зан авираар нь мэдрэх” чадвар (1.6), дараа нь тэр хүний хүргэсэн тусыг эргэн санаж сэрэх, лавлах буюу “өөр хүний туршлагатай холбон сэтгэл хөдлөлийг бий болгох” чадвар (2.4), сүүлд нь өөрийг нь тэнгэр үл таалахыг хүсэхгүйн тул үнэн тус хүргэсэн хүнийг муутгахгүй байхыг хичээх буюу

“хүссэн үр дүндээ хүрэхийн тулд өөрийн сэтгэл хөдлөлийг үр дүнтэйгээр удирдах” чадвар (4.2)-ыг сургасан гэж тайлбарлаж болох мэт. Аливаа үйл бүтэхийн урьд тархинд сэтгэхүй хийгээд сэтгэл хөдлөлийн процесс шат дараалан үүсдэг тул энэ мэт 1-4-р түвшин хүртэлх чадваруудыг хамтад нь сургамжилсан мөрүүд олон байна хэмээн үзэж болох юм.

Тус зохиолын дотор давхардаагүй тоогоор 31 мөрд нийгмийн оюун ухааныг өгүүлсэн хэмээн хүснэгт 2-т дурдсан буй. “Нийгмийн оюун ухаан” гэх ойлголтын талаар “The Cambridge Handbook of Intelligence” номд “Торндайк (Thorndike)-ийн сонгодог томъёололд: “Нийгмийн оюун ухаан гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүн хийгээд хөвгүүд, охидыг ойлгож, удирдах, хүний харилцаанд ухаалаг хандах чадварыг хэлнэ” (1920: 228) гэсэн байдаг. Үүний нэгэн адил Мосс, Хант (Moss, Hunt) нар нийгмийн оюун ухааныг “бусадтай харилцах чадвар” (1927: 108) гэж тодорхойлсон бол Вернон (Vernon) “хүмүүстэй харьцах чадвар, арга барил ба нийгмийн амар амгалан байдал хийгээд асуудлын талаарх мэдлэг, танихгүй хүмүүсийн түр зуурын эсвэл далд ааш зангийн талаар ойлголттой байх” (1933: 44) гэж хамгийн өргөн хүрээгээр тодорхойлсон”. (2020: 756) гэж дурдсан байдаг. Оюун ухааны хоёр төрөл болохын хувьд сэтгэл хөдлөлийн оюун ухааны чадваруудыг өгүүлэн буй зарим мөрд давхар нийгмийн оюун ухааныг өгүүлэх нь цөөнгүй буюу нийт 86 мөрөөр сургамжилсан байна. Тухайлбал, “Төрөл төрснөө тэтгэж явбаас, Бөх их хүчтэй болох” гэхэд бөх их хүчтэй болохын тул бусдыг тэжээн жаргаах буюу “хүссэн үр дүндээ хүрэхийн тулд бусдын сэтгэл хөдлөлийг үр дүнтэйгээр удирдах” чадвар (4.1)-ыг сургасан хэмээн тайлбарлаж болохын дээр бусадтай хэрхэн харьцах буюу нийгмийн оюун ухааныг өгүүлсэн санаатай байна.

Дээрх 2 оюун ухааны төрлөөс гадна тус сургаал дахь номлол, тунхаглалын шинжтэй, шашны агуулгатай, тайлбар сэлт болох мөрүүд нь бидний судлан буй гол агуулгад төдийлөн хамааралгүй тул тайлбарлалгүй орхив. Эдгээрээс үзвэл орчин үед хүний суралцах хийгээд ажиллах үйлд чухалд тооцогдох болсон сэтгэл хөдлөлийн оюун ухааны талаар тэртээ XIII зуунд манай өвөг дээдэс сургасан байжээ. Түүнчлэн Энэтхэг, Индонез зэрэг Азийн орнууд өнөө үед боловсролын салбар дахь сургаалын зохиолын хэрэглээг нэмэгдүүлэхээр хичээж буй аж. Индонез улсаар жишээлэхэд, “Сургаалын зохиолд суурилсан боловсролын менежмент” өгүүлэлд “Сургаалын зохиол бол тухайн үндэстний соёлын өвийн нэг хэсэг. Сүүлийн жилүүдэд сургаалын зохиолыг нэгтгэн цуглуулах нь эерэг зан чанарыг төлөвшүүлэхэд нөлөөлөх боловсролын нэг чухал үйл ажиллагаа болж байна.” (Дармади, 2018:137) гэсэн ба “Даяаршлын эрин үед сурагчдын зан чанарыг төлөвшүүлэхийн тулд Индонезийн сургаалын зохиолыг хэлний сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах нь” өгүүлэлд “Даяаршлын эрин үеийг даван туулахын тулд зөв, бурууг шийдэж чаддаг, сайн зан чанартай байх нь чухал. Тиймээс сургалтын хөтөлбөрт сургаалын зохиолуудаас оруулах замаар залуу хойч үеэ сайн зан чанарын бат бөх суурьтай болгож бэлтгэх хэрэгтэй. Гэвч энэ нь сургуулийн удирдлага, багш нар хэрэгжүүлэх энгийн зүйл биш юм. Иймд энэхүү өгүүллээрээ Индонезийн сургаалын зохиолуудыг хэлний сургалтын материалд ашиглах боломжийг зөвлөн үзүүлж байна.” (Шалэха, Пурбани, 2019:297) гэх зэргээр судлан шинжилсэн байна.

Өдгөө “Оюун түлхүүр” сургаалаас VII ангийн Уран зохиолын хичээлийн сурах бичиг (2019)-т 82 мөр, X-XI ангийн Үндэсний бичгийн хичээлийн сурах бичиг (2019)-т 42, 41, нийт 83 мөрийг хэсэглэн авч оруулсан байна. Бидний үзэхээр тус сургаалын зохиолыг зөвхөн уран зохиол, үндэсний бичгийн хичээлүүдээр уншуулах бус IV, V ангийн “Хүн ба нийгэм” хичээл, бага, суурь бүрэн дунд боловсролын “Иргэний ёс зүйн боловсрол” (бага боловсролын сургалтад “Монгол ёс, хүмүүжил” гэсэн нэрээр ордог) гэсэн 2 хичээлийн сургалтын хөтөлбөр, сурах бичигт сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулан агуулгыг хувааж, зохих мөрүүдийг сэдэвтэй холбон оруулж болох мэт. Тухайлбал, IV ангийн “Хүн ба нийгэм” хичээлийн сургалтын хөтөлбөрт “4.3б Хүмүүсийн харилцаа, хамтын амьдралыг ойлгох, тайлбарлах”, “4.3в Сурагч өөртөө үүрэг, хариуцлага хүлээхийг ойлгох, биелүүлэх” гэсэн суралцахуйн зорилтуудын хүрээнд, мөн тус хичээлийн V ангийн сургалтын хөтөлбөр дэх “5.2а Хүмүүсийн ялгаатай байдлыг (нас, хүйс, нийгэм, соёлын г.м) мэдэж, харилцах” гэсэн суралцахуйн зорилтын хүрээнд “Оюун түлхүүр” сургаалын зохиолыг сургалтын материал болгон ашиглаж болох мэт. Жишээ нь: “4.3б Хүмүүсийн харилцаа, хамтын амьдралыг ойлгох, тайлбарлах” суралцахуйн зорилтын

хүрээнд хүн хоорондын харилцаа буюу нийгмийн оюун ухааны тухай сургамжлан өгүүлсэн 86 мөрийг хэсэглэн ашиглаж болно гэх мэт.

Дээр дурдсан 2 хичээлийн хэдэн суралцахуйн зорилтын хүрээнд “Оюун түлхүүр” сургаалын зохиолыг ашиглаж болохыг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 4. Оюун түлхүүр зохиолыг ашиглаж болох суралцахуйн зорилтын тоо

| Судлагдахуун/анги         | I | II | III | IV | V  | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
|---------------------------|---|----|-----|----|----|----|-----|------|----|---|----|-----|
| Хүн ба нийгэм             |   |    |     | 3  | 1  |    |     |      |    |   |    |     |
| Иргэний ёс зүйн боловсрол | 3 | 11 | 24  | 11 | 18 | 8  | 17  | 12   | 18 | 8 | 14 | 3   |

## 5. Дүгнэлт

1.Оюуныг нээгч “Оюун түлхүүр” сургаалын зохиолын “oyun tülkigür nerete šastir orusibai”, “činggis boyda-yin nomlaysan oyun-u tülükügür orušibai”, “oyouni töülküür kemekü šastir orušibui” нэрт 3 хувилбарыг академич Ц.Дамдинсүрэнгийн эмхэтгэн хэвлүүлсэн хувилбартай агуулгаар нь харьцуулан үзэхэд, үгийн сангийн тоо ба төгсгөлийн үгс ялгаатай бол эхний мөрүүд ижил байна. Нэг хувилбарт байгаа мөр, бадаг нөгөө хувилбарт эс байх тохиолдол хэд хэд буйг дээр дурдсан бөгөөд үүний учир шалтгааныг тухайн хувилбарын бичигдсэн он цаг, газар орон, үсэг бичиг зэрэгтэй холбон цааш судалбал сонирхолтой байна. Тухайлбал, Ойрад аман аялгууг тэмдэглэгч тод үсгээр бичигдсэн 3-р хувилбар үгийн сангийн бүрэлдэхүүний хувьд бусдаасаа нэлээд ялгаатайн дээр, төгсгөлийн үгээ самгардаар бичсэн зэрэг онцлогтой байна.

2.Тус сургаалын зохиолын эрдэмтэн Ш.Чоймаагийн тодлон тайлбарласан хувилбарын агуулгыг 6 хуваан үзэхэд сэтгэл хөдлөлийн оюун ухааны чадварыг өгүүлсэн 201 мөр буюу зохиолын 45.7%, номлол, тунхаглалын шинжтэй мөр 137 буюу зохиолын 31.1%, шашны агуулгатай мөр 40 буюу зохиолын 9.1%, нийгмийн оюун ухааныг өгүүлсэн мөр 31 буюу зохиолын 7%, ёс зүйн агуулгатай мөр 17 буюу зохиолын 3.9%, тайлбар сэлт болох мөр 14 буюу зохиолын 3.2%-ийг тус тус эзэлж байна. Сэтгэл хөдлөлийн хийгээд нийгмийн оюун ухааны агуулга зохиолын 52.7%-ийг эзэлж буйгаас харахад “Оюун түлхүүр” сургаалын зохиолд оюун ухааны өгүүлэмж их болох нь илэрхий байна. Сэтгэл хөдлөлийн оюун ухааны таних, хэрэглэх, ойлгох, удирдах 4 түвшний нийт 26 чадварын 19 нь буюу 73.7% нь тус сургаалын зохиолд илэрч байна. Үлдсэн 7 чадвар нь төдийлөн илэрч харагдахгүй байгааг дорно, өрнийн ард түмний соёл сэтгэлгээний ялгаатай байдлын илэрхийлэл гэж үзэж болох бөгөөд үүнийг цааш лавшруулан судалбал сонирхолтой төдийгүй өрнийн соёл сэтгэлгээний үүднээс боловсруулсан онолыг өөрийн соёлд нийцүүлэн авахдаа нарийн судалгаа шинжилгээтэй хандах шаардлагатай хэмээн үзэж байна.

3.“Оюун түлхүүр” сургаалын зохиолын агуулгын ач холбогдолд үндэслээд тус зохиолыг ЕБС-ийн “Иргэний ёс зүйн боловсрол” (I-XII анги), “Хүн ба нийгэм” (IV, V анги) хичээлийн сургалтын хөтөлбөртэй уялдуулан хичээл сургалтад хэрэглэх саналыг дэвшүүлж байна. “Хүн ба нийгэм” хичээлийн IV ангийн 3, V ангийн 1 суралцахуйн зорилтын хүрээнд ашиглаж болох бол “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийн I ангийн 3, II ангийн 11, III ангийн 24, IV ангийн 11, V ангийн 18, VI ангийн 8, VII ангийн 17, VIII ангийн 12, IX ангийн 18, X ангийн 8, XI ангийн 14, XII ангийн 3, нийт 157 суралцахуйн зорилтын хүрээнд “Оюун түлхүүр” сургаалын зохиолыг сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах боломжтой гэж үзэж байна.

## Ном зүй

### А. Монгол хэлээр:

БСШУС-ын яам. (2019). “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, удирдамж. Улаанбаатар. [BSSHUS-yn yam. “Irgenii yos zuin bolovsrol” surgaltin khutulbur, udirdamj. [Curriculum and Guideline for Civic Ethics Education]. Ulaanbaatar.]

Дамдинсүрэн, Ц. (1957). Монголын уран зохиолын тойм. XIII–XIV зууны үе. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Damdinsuren, Ts. Mongoliin uran zokhiolyn toim. XIII–XIV zuunii uy. [Overview of Mongolian Literature: 13th–14th Centuries]. Ulaanbaatar: State Publishing House.]

- Дамдинсүрэн, Ц.** (1959). *Монголын уран зохиолын дээж зуун билиг оривой*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Damdinsuren, Ts. *Mongoliin uran zokhiolyn deej zuun bilig orihvoi*. [Hundred Selected Works of Mongolian Literature]. Ulaanbaatar: State Publishing House.]
- Лочин, С.** (2019). *Монголын эртний уран зохиол*. Улаанбаатар: Соёмбо Принтинг. [Lochin, S. *Mongoliin ertnii uran zokhiol*. [Ancient Mongolian Literature]. Ulaanbaatar: Soyombo Printing.]
- Михайлов, Г. И.** (1969). *Литературное наследство монголов*. Москва: Наука. [Mikhaylov, G. I. *Literaturnoe nasledstvo mongolov*. [The Literary Heritage of the Mongols]. Moscow: Nauka.]
- Сарангуа.** (2001). Оюун түлхүүрийн тухай ажиглалт. *Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны сэтгүүл*, 103–113. [Sarangua. *Oyun tulkhuriin tukhai ajigalt*. [Observation on Oyun Tülkhüür]. *Inner Mongolian Journal of Social Sciences*, 103–113.]
- Цэрэнсодном, Д.** (2002). *Монголын уран зохиолын товч түүх*. Улаанбаатар. [Tserensodnom, D. *Mongoliin uran zokhiolyn товч туух*. [A Brief History of Mongolian Literature]. Ulaanbaatar.]
- Чоймаа, Ш.** (2002). Их эзэн Чингис хааны билиг сургаалыг судлах асуудалд. *Үлэмжийн их Чингис хаан: Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал*, 97–101. [Choimaa, Sh. *Ikh ezen Chingis khaany bilig surgaalyg sudlah asuudald*. [On the Study of the Great Chinggis Khan's Wisdom Teachings]. The Great Chinggis Khan: Proceedings of the International Conference Dedicated to the 840th Anniversary of His Birth, 97–101.]
- Б. Гадаад хэлээр:**
- Darmadi, H.** (2018). Educational management based on local wisdom (descriptive-analytical studies of culture of local wisdom in West Kalimantan). *Journal of Education, Teaching and Learning*, 133–145.
- Lexham Press.** (2016). *Lexham Bible Dictionary*. Bellingham, WA: Lexham Press. Retrieved from <https://biblia.com/books/lbd/article/BOOKOFPROVERBS%245FWRITING.LITERARY%245FFEATUR%245FIN%245FPROVERBS.SAYINGS>
- Mustikaning Ayu Shaleha, & Widyastuti Purbani.** (2019). Using Indonesian local wisdom as language teaching material to build students' character in globalization era. *International Seminar on Language, Education, and Culture*, 292–298.
- Schneider, T. R.** (2003). Emotional intelligence predicts wise reasoning. *The Journal of Positive Psychology*, 106–120.
- Sternberg, R. J.** (2020). *The Cambridge Handbook of Intelligence*. New York: Cambridge University Press.
- Yakhontova, N. S.** (2000). The *Oyun Tülkigür* or *Key to Wisdom*: Text and translation based on the MSS in. *Mongolian Studies*, 69–137.